



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/397

Булган сум

"Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрийг танилцуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны "Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай" IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрийг танилцуулах, төр, төсвийн байгууллагын үйл ажиллагаатай танилцах уулзалт, хэлэлцүүлэгт оролцох Хөгжимт жүжгийн театрын дөрвөн уран бүтээлчдийн хоолны зардалд 640,000 (зургаан зуун дөчин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 20²⁵ оны
06 дугаар сарын 09 ны/ний өдрийн
А/397 дугаар захирамжийн хавсралт

Хөгжимт жүжгийн театрын дөрвөн уран бүтээлчдийн
хоолны зардалын төсөв

Д/д	Зардлын нэр	Оролцох хүний тоо	Хугацаа	Нэг хүний нэг өдрийн хоол	Нийт өдрийн хоол
1	2	3	4	5	6
1.	Хөгжимт жүжгийн театрын уран бүтээлчид / 1 өдөрт 3 хоол/	4	4 хоног	40,000	640,000